# 2. ЗӨГИЙН АЖ АХУЙН БАГАЖ, ТОНОГ ТӨХӨӨРӨМЖ



2-1. Зөгийчний багаж хэрэгсэл .................................................................... 63
2-2. Зөгийн бал хураах, шүүх, хадгалах, савлах багаж хэрэгсэл ............. 64
2-3. Зөгийн гэр (Үүр хайрцаг), дагалдах хэрэгсэл .................................... 65

## 2-1. Зөгийчний багаж хэрэгсэл



**Зөгийчний хувцас:** Торон малгай, бээлий, цамц, өмд, гутал



**Утуур:** Байгалийн гаралтай зүйлийн утаагаар зөгийг тайвшруулах багаж



**Цэцгийн тоос хураагуур:** Цэцгийн тоосормогийг зөгийн хөлнөөс салгаж үлдээх багаж



**Эх зөгийн дасгуур:** Эхийг шинэ бүл, бүлэнцэрт дасгах зорилгоор түр тусгаарлах хэрэгсэл



**Хэмжигч шугам**: Зөгий зорчих болон жааз хоорондын зай, жаазны хэмжээг шалгах хэрэгсэл



**Буланцар:** Утасласан жаазанд сэмжийг бэхлэх багаж



**Ховчуур:** Жаазыг хөдөлгөх, лав, жилий, бусад зүйлийг хусаж цэвэрлэх багаж



**Зөгийчний хутга:** Балтай болон эр зөгийн үрвэлдэйтэй ташаалавчны битүүмжийг авах багаж



**Үргээгүүр:** Сархиагнаас зөгийг зөөлөн шүүрдэн унагах багаж

### Бусад зүйлс:

- Хээлтүүлгийн гэр
- Зөгий шилжүүлэгч
- Дэр
- Цаваг даавуу
- Эх будагч
- Жаазны утас
- Төмөр утас бэхлэгч
- Жааз нүхлэгч
- Бал ялгуур
- Зөгийн балны шүүлтүүр (төмөр, нийлэг)
- Балны сахар, чийг хэмжигч
- Балтай жааз зөөвөрлөх хайрцаг
- Балны сав
- Жин хэмжигч
- Гэрийн бэхэлгээ
- Алх, бахь, гар хөрөө
- Услуур
- Зөгийн балны шүүлтүүр (төмөр, нийлэг)
- Балны сахар, чийг хэмжигч
- Балтай жааз зөөвөрлөх хайрцаг

- Балны сав
- Жин хэмжигч
- Гэрийн бэхэлгээ
- Алх, бахь, гар хөрөө

## 2-2. Зөгийн бал хураах, шүүх, хадгалах, савлах багаж хэрэгсэл



**Зөгий шилжүүлэгч:** Балтай жааз бүхий давхцуураас зөгийг доод давхарт шилжүүлэх хэрэгсэл



Балтай жаазыг зөөх хайрцаг



**Бал ялгуур:** Сархиагнаас балыг дүүгүүрдэн ялгах төхөөрөмж



Бал хадгалах сав, төмөр шүүлтүүрийн хамт



**Бал халаагч:** Талсжсан балыг халаах төхөөрөмж



**Шүүлтүүр**: Балыг жижиглэн савлах үед шүүх нийлэг тор



**Рефрактометр**: Балны нийт сахар, чийгийн хэмжээг тодорхойлогч багаж



**Бал савлах үеийн хэрэгсэл:** Малгай маск, бээлий, жин хэмжигч
Зураг: Касуга зөгийн аж ахуй




Балтай жааз тээвэрлэх хайрцаг

## 2-3. Зөгийн гэр (Үүр хайрцаг), дагалдах хэрэгсэл

Зөгийн гэрийн техникийн шаардлага /MNS 6829:2020/-д үндэслэн бэлтгэв. Ажлын зургийг хавсралт 3–аас харна уу.

